

**“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ 2026 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар	Гүйцэтгэлийн хувь
Стратегийн төлөвлөгөөний зорилго: Монгол Улсыг бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, оролцоог нэмэгдүүлж чөлөөт бүсүүдийг хөрш орнуудын төлөвлөлттэй уялдуулж, бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн бүсийн эдийн засаг, худалдааны хэрэгцээ шаардлагад үндэслэн чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэйгөөр хөгжүүлнэ.							
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1: Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 3.2.2.12.Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн болон нарийвчилсан төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг шинэчилнэ.							
1.1	Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулна.	-	Ажлын гүйцэтгэл	85% (2025)	100% (2026)	Барилга, хот байгуулалтын яамны сайдын 2022 оны А/10 дугаартай тушаалаар Алтанбулаг чөлөөт бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар сайдын багцаас 214.9 сая төгрөг төсөвлөгдөн Идеал групп ХХК болон Некст степ инженеринг ХХК-ийн түншлэл шалгарч 2022/304 дугаартай гэрээ байгуулсан.Тайлант хугацаанд “Идеаль групп” ХХК, “Некст инженеринг” ХХК-ийн түншлэл нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй удааширсан тул гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, ажлыг эрчимжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг богино хугацаанд батлуулах ажлыг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, гэрээг цуцлах эсэх асуудлыг шийдвэрлэх тухай хүсэлтийг захиалагч Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, захиалагчийн хяналт тавьж буй Барилга хөгжлийн төв ТӨҮГ-т 01/162 дугаартай албан бичгээр хандсан.	80%

						Барилга хөгжлийн төв ТӨҮГ-аас холбогдох талуудын уулзалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагад ерөнхий төлөвлөгөөг шаардлагад нийцүүлэн боловсруулж, 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцүүлэх үүрэг, чиглэл өгсөн талаар тайлбар, хариу ирүүлсэн. Мөн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд гэрээ цуцлуулах тухай 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 02/1133 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хуралдаанаас өгсөн санал, зөвлөмжийн дагуу дахин боловсруулж, дахин хэлэлцүүлэх үүрэг өгөгдсөн боловч тайлант хугацааны байдлаар эцэслэн хэлэлцүүлж, батлуулаагүй, төслийн хэрэгжилт удаашралтай хэвээр байна. Иймд гэрээ цуцлах асуудлыг шийдвэрлэж, шинэ гүйцэтгэгчийг шуурхай сонгон шалгаруулах шаардлагатай.	
1.2	Бодлогын баримт бичгүүд болон хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан “Чөлөөт бүсэд мөрдөх” журмын төсөл, “Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох”, “Чөлөөт бүсэд тамхи худалдах” журмын төслүүдийг	-	Боловсруулсан журам, төслийн тоо	- (2025)	2 (2026)	Эдийн засаг, хөгжлийн яаман дээр 2023 онд Ажлын хэсэг байгуулан боловсруулсан “Чөлөөт бүсэд мөрдөх нийтлэг журам”-ын төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дахин боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Шадар сайдын Ажлын албанд цахим хэлбэрээр хүргүүлж ажилласан. Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дугаар хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно”, мөн хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт “Монгол Улсад зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг энэ хуулиар зохицуулна” гэж заасны дагуу “Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох”, “Чөлөөт бүсэд	100%

	боловсруулах					тамхи худалдах“ журмын төслүүд шинэчлэн боловсруулагдах боломжгүй тухай саналыг хүргүүлж ажилласан.	
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2: Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.1.2 Бүс орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ /МУХТЖҮЧ 4.2.9, ЗГҮАХ 1.3.5.4/ 2.1.2.2. Алтанбулаг чөлөөт бүсийн ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулах							
2.1.	Алтанбулаг чөлөөт бүсийн ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад шаардлагатай төсвийг тусгуулна.	-	Ажлын гүйцэтгэл	0% (2025)	30% (2026)	Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх зорилт арга хэмжээний хэрэгжилт барилгын материалын логистикийн төв байгуулах суурь баримт бичиг боловсруулах 128.0 сая төгрөгийг 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн pimis системд шаардлагад нийцүүлэн мэдээллийг оруулсан.	50%
2.2	Алтанбулаг чөлөөт бүсээс Оросын Холбооны Улс руу чиглэсэн тусгай орц, гарцын холбох замын зураглалыг батлуулна.	-	Ажлын гүйцэтгэл	5% (2025)	30% (2026)	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 27 дугаар хуралдааны протокол, Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын 17 дугаар хуралдааны протоколуудад Монгол тал ОХУ-аас “Алтанбулаг” чөлөөт бүс руу нэвтрэх, гарах тусгай зурвас бий болгох зургийн схем зургийн төслийг Комиссын Оросын хэсгийн нарийн бичгийн дарга нарын газарт 2026 онд хүргүүлнэ гэж тусгуулсан ажлын хүрээнд: 2026 оны 03-р сарын 11-ны өдөр “Алтанбулаг” чөлөөт бүсээс Оросын Холбооны Улс руу чиглэсэн тусгай орц/гарц холбох авто замын зураглалыг мэргэжлийн байгууллагуудтай /Гаалийн ерөнхий газар, Хилийн боомтыг Захиргаа, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар/ зөвшилцөх уулзалтыг Хилийн боомтын Захиргааны байранд зохион байгуулсан. Хоёр дахь зөвшилцөх уулзалтыг Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газартай 2026 оны 04-р сарын 24-ны өдөр зохион байгуулсан. Гуравдахь зөвшилцөх уулзалтыг 2026 оны 06- сарын	50%

						04-ны өдөр “Алтанбулаг” чөлөөт бүсийн Ажлын алба, Хилийн боомтын Захиргааны албаны төлөөлөлтэй хийсэн. “ОХУ, Монгол Улсын бүс нутаг хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх 2026–2030 оны дунд хугацааны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Алтанбулаг” чөлөөт бүсийн хилийн чанад руу чиглэсэн орц/гарцын байгуулах тухай боломжийг судлах асуудлын тухай санал батлагдан орсноор Хилийн боомтын Захиргаа руу холбогдох мэдээл хүргүүлсэн болно. Хилийн чанад руу чиглэсэн орц/гарцын схем зургийн гаргах хүрээнд нийгэм эдийн засгийн дүн шинжилгээ, үр ашиг тооцоолох болон бүрэн судалгаа хийлгэх талаар Монгол Улсын ШУА-ны Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийг хийлгэх судалгаан дээр бодлогын санал дээр тохиролцож байна. Цаашид Алтанбулаг чөлөөт бүсийн гадаад орц, гарц нээх төслийг бодлогын түвшинд дэмжих, нийлэх цэг, тэнхлэгийн байршлыг баталгаажуулах, ТЭЗҮ боловсруулах санхүүжилтийг шийдвэрлэх, Дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үе шаттай хэрэгжүүлэх шийдвэр гаргах шаардлагатай талаар танилцуулга бэлтгэж Шадар сайдын Ажлын албанд хүргүүлсэн. Шууд орц гарц нээх ажилд нийт 5,228.14 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төслийн саналыг боловсруулж, 2027 оны хөрөнгө оруулалтын нэгдсэн pmis системд шаардлагад нийцүүлэн мэдээллийг оруулсан.	
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 3: Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" 2.1.2 Бүс орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ /МУХТЖҮЧ 4.2.9, ЗГҮАХ 1.3.5.4/ 2.1.2.4. Чөлөөт бүсүүдийн инженерийн дэд бүтцийг байгуулах							
3.1	Алтанбулаг чөлөөт бүс доторх 13.8 км авто зам, чөлөөт бүсээс хил хүртэлх хүзүүвчний хэсгийн 0.81 км авто зам болон Авто замын борооны ус зайлуулах барилга байгууламжийн	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	5% (2025)	50% (2026)	2027 оны төсөвт тусгуулахаар саналаа хүргүүлсэн.	50%

	ажлыг гүйцэтгүүлэхээр улсын төсөвт тусгуулна.						
3.2	Алтанбулаг чөлөөт бүсэд хийгдэж буй цахилгаан өртгөтгөлийн барилга угсралтын ажлыг гэрээний хугацаанд бүрэн дуусгаж хүлээн авах ажлыг зохион байгуулна.	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	95% (2025)	100% (2026)	Улсын комиссын дүгнэлт 2025.12.23-ны өдрийн 83/2025 дугаар баталгаажсан ба үүрэг даалгаврын биелэлтээр улсын комисс хүлээн авсан. Улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар 2026.05.15-ны өдөр хангагдсан бөгөөд актаар хүлээж авах ажлыг зохион байгуулан ажилласан.	100%
3.3	Алтанбулаг чөлөөт бүсийн ус хангамж ариутгах татуургын шугам хоолойд үзлэг шалгалт хийж, туршилт явуулах хуваарь гаргах, засвар үйлчилгээг хийж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	10% (2025)	100% (2026)	Төлөвлөгөөний дагуу 2026 оны 06 дугаар сарын 04-нд чөлөөт бүсийг аймагтай холбосон 25км 325ш бохир усны худгийн бүрэн бүтэн байдал, чөлөөт бүсийг сумтай холбох шугамуудад үзлэг хийж хүн, мал амьтны аюулгүй байдлыг хангаж, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан.	100%
3.4	Байгуулллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дэд бүтцийн барилга байгууламж, бусад хөрөнгийн ашиглалт, харуул хамгаалалт, засвар үйлчилгээ арчилгааг хариуцан	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	Сүхбаатар-Алтанбулагын бохир усны цахилгаан хангамжийн 19.8 км, Улаан бургасны хөндийд байрлах цэвэр усны 7 худгийн цахилгаан хангамжийн 11.8 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дагалдах тоноглол, дэд станцын трансформаторуудад үзлэг хийсэн. Үзлэгээр цэвэр усны 7 худгийн № 85,86,87,88, 45,46,47 дугаартай тулгуурууд намагтай хөрсөнд байгаа тул суулт өгч налсныг яаралтай тэгшлэхгүй бол тулгуур унах, хугарах эрсдэлтэй байна. 2026.04.14-ний өдөр Бүсийн 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд хүчтэй салхины улмаас ХТП-21-ын төгсгөлийн тулгуурын С фазын хөндийрүүлэгч излятор таревирисээс мултарсныг эрчим хүчээр хангагч байгууллагад мэдэгдэж,	100%

	тогтмол үзлэг хийж, найдвартай ажиллагааг хангана.					хүчдэлээ салгаж, насжилт хэтэрч муудсан модон тулгууртай тул маргааш нь авто кранаар дээшээ гарч гэмтлийг устгаж хэвийн байдалд оруулсан. - 2026.04.06-ний өдөр ЗАА-ны байр, ААН-ийн хуваарилах самбар, ерөнхий самбаруудад үзлэг хийсэн. -Шалган нэвтрүүлэх байрны дулаан хангамжийг сайжруулах, ажил үйлчилгээ явуулах нөхцөлийг хангахад чиглэсэн үзлэг шалгалт хийж 4ш радиаторыг шинээр сольж тавьсан. -Оффисын байрны барилгын засвар, дулаан хангамжийн байдлыг Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газарт хүсэлт гарган, хамтарсан үзлэг шалгалт хийж дүгнэлт гаргуулсан.	
3.5	Алтанбулаг чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдэд Архитектур төлөвлөлтийн даалгавар гаргах, заавар зөвлөмж өгөх, ирүүлсэн барилгын эскиз зурагт тавигдах шаардлага, барилгын норм ба дүрмийн дагуу боловсруулсан эсэхэд хяналт тавьж ажиллана.	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	-“Хур ирмүүн чөлөөт бүс” ХХК-ны эзэмшиж ашиглаж буй газарт баригдаж байгаа барилга байгууламжид хяналт тавьж үе шат дараалал, зураг төсөл, барилга угсралтын явцад тавигдах шаардлага, норм ба дүрмийн талаар заавар зөвлөмж дахин өгч ажилласан -“Итирнатитур чөлөөт бүс” ХХК-ны өөрийн эзэмшиж, ашиглах талбайд баригдах барилгын зураг төсөлд хяналт тавьж баталгаажуулав. -“Алтангадас трейд” ХХК-ны албан хүсэлтийн дагуу архитектур төлөвлөлийн даалгаврыг боловсруулж өгөв.	100%
3.6	Алтанбулаг чөлөөт бүсэд Аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилга бүтээн байгуулалтын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгаа өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэн арга зүйн зөвлөгөө өгөх, комиссын бичиг баримтын	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	“Алтанбулаг” чөлөөт бүсэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, дадлага, хяналт шалгалт зохион байгуулах тухай” удирдамжийн дагуу 2026.04.10 өдөр Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газартай хамтран дараах агуулгаар танхимын болон гадаах дадлагын үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: ✓ Гамшгаас хамгаалах хууль, тогтоомж ✓ Зөвлөмж, мэдээлэл ✓ Гал унтраах арга, практик дадлага Мөн үйл ажиллагаа эрхэлж байгаа 25 дэлгүүрээр Онцгой байдлын газрын шинжээчид болон ЗАА алба хаагчид хамтран үзлэг, шалгалтын ажлыг	100%

	бүрдэлтэд хяналт тавьж ажиллана.					зохион байгууламж, зөвлөмж өгч ажилласан. -“ Хаан ертөнц чөлөөт бүс” ХХК нь агуулахын сууриа ухах үедээ өөрийн цахилгааны кабелиа гэмтээсэн байсныг засварлаж хэвийн байдалд оруулж, ажил гүйцэтгэгчид аюулгүй ажиллах зааварчилгаа өгч ажилласан. - ААН-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа “Эй Өү Ди Кю” ЧБ ХХК, “ “Шинэ үндэс” ЧБ ХХК, “Бум буянт од”ХХК, “Хур ирмүүн билэг” ХХК, “Хаан ертөнц” ХХК, “Итирнатитур” ЧБ ХХК, “Алтангадас”ХХК, “Ханбүргэдэй” ХХК -ны барилга байгууламжийн төслийн бүрдүүлэх материалын жагсаалтыг гаргаж, асуудлыг албан бичгээр хүргүүлж шийдвэрлэсэн болно. -“Хур ирмүүн билэг” ЧБ ХХК, “Цахим ертөнц” ЧБ ХХК-ний барилга дээр ажиллаж буй нийт 12 ажилчинд бүсийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаархи ХАБЭА-н зааварчлага тус бүр 2 удаа өгсөн.	
3.7	Улсын комисс ажилласан барилга байгууламжийн эргэлтийн цэгүүдийг газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэнэ.	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	Тайлант хугацаанд Силк роуд интернейнл чөлөөт бүс ХХК-с ирүүлсэн хүсэлтийн дагуу 275 м.кв барилгыг эргэлтийн цэгийн дагуу мэдээллийн санд оруулж, кадастрын зургийг шинэчилсэн.	100%
3.8	Цахилгаан эрчим хүчинд холбогдохыг хүссэн, чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид техникийн түр нөхцөл олгож, холболт хийлгэх, хяналт тавьж ажиллана.	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	Тайлант хугацаанд “Таванхан хайрхан” ХХК-иас хүсэлт ирүүлсний дагуу 36 кВт-ыг цахилгаан эрчим хүчний техникийн нөхцөл олгосон.	100%

Зорилт 4 Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт:

Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, үүрэг даалгаврын холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, хянах, тайлагнах, авлига үүсэх эрсдлийг бууруулах, хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, хүний нөөцийн хөгжлийн болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Байгууллагын

архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийг баяжуулж, цахим сан бүрдүүлэх, албан хаагчдад мэргэжил, арга зүйн заавар зөвлөгөө өгөх, Төсөв санхүүг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах болон бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод хяналт хийх, эрсдэлээс урьдчилсан сэргийлэх							
4.1	Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн 2026 оны газар олголтын төлөвлөгөөг боловсруулж дээд шатны байгууллагад танилцуулах, хуулийн хүрээнд газар ашиглах эрхийг иргэн, аж ахуй нэгжид олгох	-	Иргэн, аж ахуй нэгжид олгосон газар ашиглах эрхийн тоо	0 (2025)	0 (2026)	“Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн боловсруулагдаж байгаатай холбоотойгоор Хот байгуулалтын тухай хуулийн 24 дүгээр зүйл 24.2-т /Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шийдвэрт хамрагдсан тухайн газар нутагт газар эзэмших, ашиглах эрх олгох болон хот байгуулалтын бусад үйл ажиллагаа явуулахыг тодорхой хугацаагаар түр зогсооно/ заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хот байгуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1.7-д заасны дагуу ерөнхий төлөвлөгөө эцэслэн батлагдсаны дагуу Чөлөөт бүсийн тухай хуулийн 22 дугаар зүйл 22.4-т заасны дагуу төсөл сонгон шалгаруулах, дуудлага худалдааны аль нэг хэлбэрийг ашиглан шинээр газар ашиглах эрхтэй болно. Өнөөдрийн байдлаар чөлөөт бүсэд 107 аж ахуйн нэгж, 128 нэгж талбарыг эзэмшиж, ашиглаж байна.	80%
4.2	Алтанбулаг чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийг бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох, сунгах, согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах зөвшөөрөл	-	Иргэн, аж ахуй нэгжид олгосон үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, газрын төлбөр ногдуулалтын тоо	14 (2025)	14 (2026)	Газрын төлбөрийн орлого 7931.3 мян.төг, бусад төлбөр хураамжийн орлого 8814.0 мян.төг Шалтгаан: Чөлөөт бүсэд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн 2026 оны гэрээ дүгнэх ажлын хэсгийн дүгнэлт 2026 оны 06 дугаар сарын 02 ны Захирагчийн зөвлөлийн хурлаар орж батлагдсан. 2026 онд 127 нэгж талбарын 83976.0 мян төгрөгийн газрын төлбөрийн ноогдуулалт, цагдаа, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 86271.9 мян төгрөгийн газрын төлбөрийн авлага барагдуулахаар ажиллана. • Шүүхэд нэхэмжлэл гаргах ААН -3	50%

	олгохтой холбоотой хураамж, төлбөр тооцоо, газрын төлбөрийг зохих журмын дагуу бүрдүүлэх, тайлагнах ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллана.					• ШШГБ ажиллагаа хийгдэж байгаа ААН - 1 • Эрэн сурвалжлагдаж байгаа ААН- 4 • Шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон ААН -1 • Өмнөх оны төлбөрийн үлдэгдэлтэй ААН - 2	
4.3	Чөлөөт бүсийн зорчигч ийнтээврийн хэрэгсэл, бараа эргэлтийн мэдээг сар, улирал, жилээр гаргах, чөлөөт бүсэд нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүний нэр төрлийн өсөлт, экспорт, импортын барааны харьцуулалтын тайлан мэдээ гаргах, мэдээллийн сан үүсгэнэ	-	Хөрөнгө оруулагчдын экспортын бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээний тоон үзүүлэлт	80 (2025)	90 (2026)	2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл: Нийт зорчигч 179969 үүнээс гадаад зорчигч 3309 /30 орон/ Нийт тээврийн хэрэгсэл 52383 үүнээс гадаад тээврийн хэрэгсэл 989 Бараа эргэлт : Нэвтэрсэн бараа 4779.4 мянган доллар Борлуулалт 4613.7 мян доллар байна. 2026 оны 1 улиралыг өмнөх оны мөн үетэй харьцуулвал: Тээврийн хэрэгсэл 12.9% Зорчигч 13.9% Бараа эргэлт 21.9% хувиар өссөн ,нийт барааны нэр төрөл 83, байнгын үйл ажиллагаа явуулж буй дэлгүүрийн тоо 32 байна. 2026 оны эхний хагас жилийн бодит гүйцэтгэлийг 7 дугаар сарын 5 ны дотор ГЕГ-ын Статистик газраас авч Dashbaord дээр боловсруулж гаргана.	100%
4.4	Байгууллагын батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтлөх, төсвийн хүрээнд зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж, өглөг, авлага үүсгэхгүй, гүйцэтгэлийг хуулийн хугацаанд нь сар, улирал, жилээр тайлагнаж, шилэн	1,865.9	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	2026 оны 1 ээс 5 дугаар сарын төсвийн урсгал зардлын гүйцэтгэл. Цалин, урамшуулал ,унаа, хоол, татвар , НДШ Батлагдсан төсөв 777,2 сая төгрөг • Зарцуулалт 559.8 сая төгрөг • Хэмнэлт 217.4 сая төгрөг • Хувь 28 % • Бусад зардлууд тайлант хугацаанд төсвийн хуваарь батлагдаагүй болно. Тайлант хугацаанд байгууллагын 64 ажил гүйлгээг Шилэн дансны мэдээлэл хуулийн хугацаанд нь	100%

	дансны мэдээллийг тогтмол хуулийн дагуу хөтлөнө.					оруулсан.	
4.5	Байгууллагын урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүгийн жилийн батлагдсан төсвийн тодотгол, төсвийн төсөл, төсөөллийг батлагдсан аргачлалын дагуу бодитой төлөвлөх, хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлийг хянаж ажиллана.	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	Төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчын төсвийн хязгаарт өгөх байгууллагын Урсгал зардлын 2027 оны төсвийн төсөл, 2028,2029 оны төсвийн төсөөлөлийн саналаа бэлтгэж 2026 оны 06 дугаар сарын 04 ны өдөр хүргүүлсэн. Төсвийн санал 5,843.8 сая төгрөг ХОХБХэлтэс Улсын төсвийн хөрөнгө оруулалтанд саналаа мөн хүргүүлсэн.	100%
4.6	Байгууллагын мөнгөн хөрөнгө, бараа материалын үнэт зүйл, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг шалган баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд актлах саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж, шийдвэрийг үндэслэн бүртгэлийг хийж гүйцэтгэнэ.	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	4 жил тутам Улсын хэмжээнд явагддаг хөрөнгийн үзлэг тооллого энэ онд явагдаж байгаа бөгөөд удирдамжийн дагуу UMCH.GOV.MN цахим системд 2025 оны 12 дугаар сарын 31 ны байдлаарх хөрөнгийн үлдэгдэлийг оруулж бэлтгэл байдлын хангасан, цаашид дээрх цахим системийн хөгжүүлэлт хийгдэж дуусангуут чиглэл авч дээрх ажил хийгдэж дуусана. 2026 оны хагас жилийн байгууллагын хөрөнгийн тооллого дээрх ажлын гүйцэтгэлээр хийгдэнэ.	100%

4.7	Алтанбулаг чөлөөт бүсийн экспортод чиглэсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах зорилтын хүрээнд эвент арга хэмжээнүүд санаачилж зохион байгуулна.	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	1 (2025)	2 (2026)	2026 оны 06 дугаар сарын эхний 7 хоногт Алтанбулаг чөлөөт бүс дээр БНХАУ-н Хөх хотын захиргаа, тус хотын чөлөөт бүс, бизнес эрхлэгч нартай хамтарсан Хөрөнгө оруулалтын экспо-г зохион байгуулахаар тус хотод суугаа Монгол улсын ерөнхий консулын газартай хамтран бэлтгэл ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байсан боловч захирагч солигдсоноор уг ажил тодорхойгүй шалтгаанаар хойшилсон болно. Монгол, Хятад хоёрулсын “Алтанбулаг чөлөөт бүс, хөрөнгө оруулалтын Экспо-2026”-ны Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суман дахь чөлөөт бүс дээр зохион байгуулахаар төлөвлөж байсан хөтөлбөр, ажил үүргийн хуваарь, календарьчилсан төлөвлөгөө, танилцуулга, видео танилцуулгын зохиол,оролцогч талуудын мөрдөх журам, үндэсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн жагсаалт, уриалга зэргийг бэлэн болгосон. Мөн 2026 оны 8 сард төлөвлөж байсан “Алтанбулаг” чөлөөт бүс дэх “Цайны зам”-ын Монгол, Хятад, Орос гурван улсын соёл, аялал жуулчлалын хамтарсан Экспо-2026” удирдамж бэлтгэсэн. Дээрх төлөвлөгдөж байсан “Алтанбулаг” чөлөөт бүс хөрөнгө оруулалтыг Экспо-2026 арга хэмжээний хүрээнд Соёл, спорт,аялал жуулчлал залуучуудын яамтай хамтарсан уулзалт хийж, Экспоны тухай мэдээлэл бэлтгэсэн. МҮХАҮТ-тай хамтран ЕАЭХ-ны зах зээлд экспорт хийдэг 78 гаруй компаниудыг хамруулах, хамтарсан үүлзалт зохион байгуулах арга хэмжээний бэлтгэл ажлыг ханган ажилласан. УИХ-ын гишүүн, Монгол Улсын Шадар Сайд Н.Номтойбаяр болон Ажлын албаны удирдлага, албаны хүмүүс 2026 оны 05-р сарын 23-ны өдөр “Алтанбулаг” чөлөөт бүс дээр бизнес, хөрөнгө	50%
-----	--	---	--------------------------------	-------------	-------------	--	-----

						оруулагч ААН-тэй хийх уулзалтын хүрээнд нийт 24 Үндэсний үйлдвэрлэгч ААН-тэй холбоо тогтоож, уулзалт зохион байгуулж, “Алтанбулаг” чөлөөт бүсэд экспортын үйл ажиллагаа явуулах, боломж, давуу талуудын тухай санал солилцсон. Дээрх арга хэмжээний бэлтгэл ажлыг хангасан	
4.8	Байгууллагын www.altanbulag.gov.mn вэбсайт болон бусад олон нийтийн цахим мэдээллийн хэрэгсэлд бүсийн талаарх мэдээ, мэдээллийг байршуулан олон нийтэд хүргэх, хамтын ажиллагаатай байгууллагуудад мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, Хөрөнгө оруулагчид болон бүсийн удирдлагуудыг гарын авлага, мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.	-	Мэдээ, мэдээллийн тоо	16 (2025)	20 (2026)	Олон нийтийн цахим мэдээллийн хэрэгсэлд бүсийн талаарх мэдээ, мэдээллийг байршуулан олон нийтэд болон хамтын ажиллагаатай байгууллагуудад хүргэн ажиллаж байна. Фейсбүүк хуудасны идэвхийг нэмэгдүүлж, 7 хоногт тогтмол дараах мэдээллийг байршуулж байна: Чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын мэдээ, видео-50, “Чөлөөт бүсийн тухай” хуулийн зохицуулалт, чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам постер-18, Иргэний асуулт, хариулт постер-19, үйл ажиллагаа эрхэлж буй ААН байгууллагын импортын мэдээ постер-11, Улаанбаатар хот болон Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын цаг агаарын видео, постер-33, “Алтанбулаг” чөлөөт бүсийн 2026 оны 4-р сарын зорчигч болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний статистик мэдээлэл-1, Зорчигч тээврийн хэрэгслийн статистик мэдээ-33, постер, бусад мэдээ мэдээлэл-80, Шадар сайдын Ажлын албаны холбогдох мэдээ мэдээлэл-47 нийт 292 төрлийн мэдээллийг олон нийтэд хүргэсэн. “Цэвэр орчин-хамтын хариуцлага” постерийн эх загвар бэлтгэж түгээсэн. https://altanbulag.gov.mn/ Веб сайтын ил тод байдал үндсэн цэсэд шинэчлэл хийж байгууллагын танилцуулга холбоос хэсгийг шинээр үүсгэсэн. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас https://e-mongolia.mn/org/altanbulagchulu нэгдэж байгууллагын мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж байгууллагын цахим хуудасны бэлэн	100%

					байдлыг хангаж байна. Алтанбулаг чөлөөт бүс нь 2026 оны I улиралд “Шил ажиллагаа shilen.gov.mn” сайтын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 99.01 хувиар үнэлүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг ил тод, нээлттэй байлгаж, цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн ханган, мэдээллийг тухай бүр шинэчилж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах албатай харилцан мэдээ мэдээллийг солилцож, Засаг даргын тамгын газрын хуудсаар байршуулж байна. “Алтанбулаг” чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, чөлөөт бүсийн хөгжлийг хурдасгах чиглэлээр санал солилцсон мэдээг “Монцамэ” агентлагийн орон нутгийн мэдээгээр сурталчлан таниулсан. Монгол Улсын Шадар сайдын Ахлах зөвлөх харьяа байгууллагуудын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгжийн дарга, ахлах мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулсан. https://mail.gov.mn/ Төрийн цахим шууданд шинээр томилогдсон албан хаагчдын бүртгэл нээж, нууц үг түгжигдсэн албан хаагчдын хаягийг сэргээв. 2022-2025 онуудад гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээллийн технологи, хэвлэл мэдээллийн ажлын чиглэлэр хийгдсэн ажлын тойм 10 хуудас материал боловсруулж бэлтгэсэн.	
--	--	--	--	--	---	--

4.9	Гадаад, дотоод чөлөөт бүсийн үйл ажиллагааг судлах, зах зээлийн боломж, эрэлт хэрэгцээг тодорхойлсон суурь судалгаа боловсруулж мэдээллийн сан үүсгэнэ.	-	Судалгааны тоо	10 (2025)	10 (2026)	1. Алтанбулаг чөлөөт бүсэд нийт 126 нэгж талбарт 108 аж ахуйн нэгж бүртгэлтэй байна. Үйл ажиллагааны чиглэлээр ангилан үзвэл логиستيкийн чиглэлээр 3, агуулахын чиглэлээр 3, захиргааны чиглэлээр 7, үйлдвэрлэлийн чиглэлээр 4, нөөцийн чиглэлээр 3, худалдааны чиглэлээр 88 аж ахуйн нэгж тус тус байна. 2026 оны эхний хагас жилд аж ахуйн нэгжүүдийн эзэмшил, ашиглалтад байгаа барилга байгууламжийн үндсэн мэдээлэл, зориулалт, ашиглалтын байдал, хөрөнгийн үнэлгээний үзүүлэлтүүдийг нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд хөрөнгийн үнэлгээг албажуулан ирүүлсэн 18 аж ахуйн нэгжийн нийт 15,358,000,000 (арван таван тэрбум гурван зуун тавин найман сая) төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн талаар судалгаа мэдээллийг нэгтгэн боловсруулав. 2. Бүгд Найрамдах Солонгос Улсын Чөлөөт бүсийн тухай хуулийн судалгаа хийсэн. Бүгд Найрамдах Солонгос Улсын чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны тогтолцоо болон хөрөнгө оруулалтын орчныг судлах зорилгоор тус улсын Чөлөөт бүсийн тухай хууль болон холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд судалгаа хийж судалгааны хүрээнд чөлөөт бүс байгуулах үндэслэл, удирдлага зохион байгуулалтын тогтолцоо, хөрөнгө оруулагчдад үзүүлэх дэмжлэг, татварын болон гаалийн хөнгөлөлт, дэд бүтцийн хөгжүүлэлт, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зохицуулалт зэрэг асуудлуудыг судалж, мэдээллийг нэгтгэн боловсруулав. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааны туршлага, хөрөнгө оруулалт татах бодлого, бүсийн хөгжлийн менежментийн онцлогийг судалж, Монгол Улсын чөлөөт бүсийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжтой сайн туршлагуудыг тодорхойлов. Судалгааны үр дүнгээр гарсан мэдээлэл,	100%
-----	---	---	----------------	--------------	--------------	---	------

						дүгнэлтийг цаашдын бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, чөлөөт бүсийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр ашиглах боломжтой суурь материал болгон бэлтгэсэн.	
4.10	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт хийх сонирхол бүхий аж ахуй нэгж, байгууллагуудтай холбоо тогтоох хамтран ажиллана.	-	Хамтран ажиллах аж ахуй нэгжтэй хийсэн уулзалтын тоо	5 (2025)	10 (2026)	“Монгол-Оросын бүс нутгийн анхдугаар чуулга уулзалт”-ын хүрээнд Оросын Холбооны Улсын Эрхүү мужийн “Байкальская строительная компания”-ын төлөөлөгч нартай хамтарсан уулзалт хийсэн. Мөн Эрхүү мужийн “Автоматизация систем” компаний захирал Р.А. Шванд-тай хамтарсан уулзалт хийж, “Алтанбулаг” чөлөөт бүсийн цэвэр ус болон ус цэвэршүүлэх байгууламжийг шинэчлэх, өргөжүүлэх тал дээр шинээр тооцоо гаргуулах тухай санал бодлоо солилцсон. ОХУ-ын “Дэмт Плас Энди” ХХК тээврийн компаний захирал Е.В. Добрынин-тай хамтарсан уулзалт хийгдсэн. БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин Сайд хатагтай Шэнь Минь Зюаньтай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. БНХАУ-ын ЭСЯ-ны Эдийн засаг, худалдааны газрын нарийн бичгийн дарга н.Саруул болон Хөх хотын Татварын баталгаат ерөнхий бүсийн ажилтан н.Өөдлөх нартай холбогдон ажиллаж байна. Үндэсний үйлдвэрлэгч 24 аж ахуйн нэгжтэй холбоо тогтоож, чөлөөт бүсэд хөрөнгө оруулах, хамтран ажиллах урилга, гарын авлага, чөлөөт бүсийн тухай хууль зэргийг хүргүүлсэн. • Туркийн Хамтын ажиллагаа, зохицуулалтын агентлаг (ТИКА) • ДЭМБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар, • Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага	100%

						• ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар • Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газар • Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA) • Азийн хөгжлийн банк (АХБ)-ны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар • Дэлхийн Банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар, • Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO)-ын төлөөлөгчийн газруудад хамтран ажиллах тухай албан бичгийг хүргүүлсэн. -“Tourism week-2026” арга хэмжээний үеэр ССАЖЗЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга В.Батчимэг Аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлийн талаарх илтгэл хэлэлцүүлэгт оролцож, холбогдох мэдээлэл авсан. Монгол Улсын ШУА-ны Газар зүй, геоэкологийн хүрээлэнгээс зохион байгуулсан Монгол Улсын хилийн боомтын өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ,ба эдийн засгийн төрөлжилт чиг үүргийг тодорхойлох бодлогын хэлэлцүүлэгт оролцсон.	
4.11	Чөлөөт бүсийн үйл ажиллагааг хөрөнгө оруулагчдад сурталчлах, танилцуулга бэлтгэнэ.		Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	ЕАЭХ-ны зах зээлд экспорт хийдэг компаниудыг хамруулах хүрээнд , 24 ААН-тэй тус бүр хамтарсан үүлзалт зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны тухай сурталчлан таниулсан . БНХАУ, БНТУ-ын холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй харилцсан харилцааны товчоог гарган танилцуулсан. Алтанбулаг чөлөөт бүсийн 2025 онд хийж хэрэгжүүлсэн онцлох ажил видео танилцуулгыг байгууллагын фэйсбүүк, www.altanbulag.gov.mn	100%

						хуудас, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын фэйсбүүк хуудсаар, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк хуудсаар түгээн, сурталчилсан.	
4.12	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, холбоотой дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлэх	-	Хэрэгжилтийн хувь	100% (2025)	100% (2026)	Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд: 1.2026 онд Монгол улсын Шадар сайд Х.Ганхуягийг оролцуулах саналтай арга хэмжээ болон үйл ажиллагааны талаарх мэдээлэлд “Алтанбулаг” чөлөөт бүс ба “Монгол-Хятадын анхдугаар хөрөнгө оруулалтын Экспо-2026” арга хэмжээнд оролцуулах талаар санал бэлтгэн явуулсан 2. Монгол Улсын Улсын Их дарга Н.Учрал-ын 2026 оны 02-р сарын эхээр Оросын Холбооны Улсад хийх айлчлалын хүрээнд “Алтанбулаг” чөлөөт бүсийн зүгээс Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 27 дугаар хуралдааны протоколд орсон саналыг дахин анхааралдаа авах тухай санал бэлтгэн хүргүүлсэн 3. Монгол улсын Шадар сайдын 2025 оны 182 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлттэй холбогдуулан тайлбар, “Чөлөөт бүсийн тухай” хуулийн дагуу чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааны талаар мэдээлэл, гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр хийсэн ажлын талаарх танилцуулгыг хүргүүлсэн. -Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд Н.Номтойбаяр 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Алтанбулаг чөлөөт бүсэд ажиллаж, бүсийн өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн асуудалтай газар дээр нь танилцсан. -Монгол улсын Шадар сайдын салбарын хэмжээнд хийж хэрэгжүүлсэн сар бүрийн ажлын тайланг	100%

						бэлтгэн явуулдаг. -Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд бөгөөд дипломат корпусын ахлагч эрхэмсэг ноён Евсиков А.Н.-д албан хүсэлт, хэлэлцэх асуудал боловсруулж бэлтгэсэн. БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин Сайд хатагтай Шэнь Минь Зюаньтай зохион байгуулах уулзалтын албан бичиг, ярианы сэдэв, уулзалтын хөтөлбөр зэргийг боловсруулж бэлтгэсэн. Монгол Улсын Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)-ын эрхлэх байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг 4 дүгээр сарын 14-ний өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдаж, тус арга хэмжээнд Алтанбулаг чөлөөт бүс оролцож, хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын боломж, хөгжлийн чиглэл, онцлог давуу талаа олон нийтэд танилцуулсан. Монгол Улсын Шадар сайдын Ахлах зөвлөх харьяа байгууллагуудын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгжийн дарга, ахлах мэргэжилтнүүдтэй уулзалтанд оролцсон.	
4.13	Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийг төлөөлөн шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн өмнө бүрэн хариуцна.	-	Шүүхийн маргааны шийдвэр, явц	100% (2025)	100% (2026)	“Нэг бүс чөлөөт бүс” ХХК нь 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 197/ШШ2025/17747 дугаартай Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шийдвэрээр 3,240,000 төгрөгийн газрын төлбөрийг төлүүлэхээр шийдвэрлэсэн. Гэвч тус компани нь шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэлгүй өнөөдрийг хүрч, албадан төлүүлэхээр гүйцэтгэх хуудас гаргуулахаар хүсэлт хүргүүлсэн.	80%

4.14	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө боловсруулан батлаж хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	90% (2025)	100% (2026)	Байгууллагын албан хаагчдын сургалтын 2026 оны төлөвлөгөөний дагуу дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд; 1. Удирдлагын академийн Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч; 2. АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс боловсруулсан мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлагын дагуу онлайн сургалтыг 9 албан хаагч 2 удаа; 3. Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газартай хамтран чөлөөт бүс дээр зохион байгуулсан “Гамшигаас хамгаалах тактик”-ийн сургалтад 21 албан хаагч; 4. Ёс зүйн дэд хороотой хамтран зохион байгуулсан сургалтад 30 албан хаагч тус тус хамрагдсан. Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө дагуу дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан. 1. Засгийн газрын 2025 оны 226 дугаар тогтоолыг үндэслэн албан хаагчдын цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн тогтоосон. 2. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв шинээр авах болон ахиулах албан хаагчдын судалгааг гарган Монгол Улсын Шадар сайдын 2026 оны 65 дугаар тушаалаар 10 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон. 3. Төрийн дээд одон мядалиар шагнуулах болзол хангасан 6 албан хаагчийн материалыг бүрдүүлэн Монгол Улсын Шадар сайдын Ажлын албанд хүргүүлж, Сар шинийн баяраар 5 албан хаагч шагнуулсан. 4. Байгууллагын албан хаагчдыг шинээр орон	90%
------	--	---	-------------------	------------	-------------	---	-----

						сууцтай болгох болон орон сууцны нөхцөлөө сайжруулах зорилгоор Худалдаа хөгжлийн банкттай 2025 онд хамтран ажиллах гэрээг байгуулан зээл авахад нь дэмжлэг үзүүлэн ажилласан. 5. Ажлын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн стандарт жишигт нийлүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэн ажлын байранд дотор заслын ажил хийгдсэнтэй холбогдуулан цонхны хөшиг, хувцасны шүүгээ, бичиг хэргийн шүүгээ, албан хаагчдын хувийн хэргийн шүүгээ, ус цэвэршүүлэгчийг шинээр авсан. Мөн бусад байгууллагаас 3 суурин компьютер, 4 ширээ, сандал, хурлын 5 ширээг шилжүүлэн авч шинэчлэн ажилласан. 6. Орон нутгийн нэмэгдлийн талаарх албан хаагчдын хүсэлт, холбогдох материалыг бүрдүүлэн УИХ-ын гишүүн Ч.Ундрамд албан бичгээр 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01/182 тоот албан бичгээр хүргүүлнэ. Дэвшилтэд технологийг албандаа нэвтрүүлэн https://erp.e-mongolia.mn/, https://e-business.mn/ цахим системүүдийг нэвтрүүлэн цаасгүй технологи бий болгохоор ажиллаж байна.	
4.15	Сахилга хариуцлага дэг журмыг сайжруулах талаар бодитой арга хэмжээ зохион байгуулан хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, ёс зүй, ажлын гүйцэтгэл, цаг ашиглалт, хөдөлмөрийн сахилга, дэг журмыг сахиулах, хяналт тавина.	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	Албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүй, ажлын цаг ашиглалт дээр тогтмол хяналт тавьж, сар бүрийн 25-нд цаг бүртгэлийг нэгтгэн ажлын цаг ашиглалт дээр анхаарч ажиллахыг мэдэгдэх хуудсаар сануулан, зөрчил гаргасан албан хаагчид хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан.	100%

4.16	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, сайжруулах дүгнэлт гаргана.	-	Ажлын явц, гүйцэтгэлийн хувиар	100% (2025)	100% (2026)	Чөлөөт бүс дээр ажиллаж байгаа албан хаагчдын ажлыг 2026 оны 1 дүгээр сарын 8-9-ний өдрүүдэд гэнэтийн байдлаар очиж шалгасан.Үүнд; 1. албан хаагчдын ирц, 2. ажлын байрны зураг авалт, 3. ажлын давхардал хийдэл зэрэг дээр дотоод хяналт шалгалт хийж ажилласан. - Улаанбаатар хотод ажиллаж байгаа нийт албан хаагчдын ирцэнд 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хяналт тавьж 60 минутаас дээш хоцролт таслалтай байгаа 10 албан хаагчдад сануулах хуудас өгч цаашид хоцорч таслахгүй байх талаар анхааруулан ажилласан. - Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд ирсэн шалгалтанд дотоод хяналтын зүгээс хийж хэрэгжүүлсэн 2 жилийн ажлын тайлангаа хяналт, шалгалтаар оруулж дүгнэлт гаргуулж ажилласан.	100%
4.17	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ зохион байгуулах, биелэлтийг ханган ажиллана.	-	Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан гүйцэтгэлийн хувь	100% (2025)	100% (2026)	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрандаа видео бичлэг тоглуулах дэлгэцийг байршуулан тогтмол цагт явуулан ажиллаж байна. Мөн мэдээлэл, ил тод байдлын самбар, санал хүсэлтийн хайрцагийг шинэчлэн байршуулсан.	100%

4.18	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	100% (2025)	100% (2026)	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/27 дугаар захирамжаар батлуулан албан хаагчид мөрдлөг болгон ажиллаж байна.	100%
4.19	Алтанбулаг чөлөөт бүсэд инженерийн шугам сүлжээний зураг төсөв, барилга угсралтын ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтын саналыг боловсруулж, холбогдох газарт хүргүүлнэ.	-	Саналын тоо	3 (2025)	3 (2026)	Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх хүрээнд 1. Чөлөөт бүсийн доторх хүзүүвч 14.51 км хатуу хучилттай стандартын шаардлага хангасан авто замын барилга угсралтын ажилд 71,160.37 сая төгрөг, 2. Чөлөөт бүс доторх 13.8 км авто зам болон чөлөөт бүсээс улсын хил хүртэлх 0.81 км авто замын борооны ус зайлуулах шугамын барилга угсралтын ажилд 5,022.08 сая төгрөг, 3. Оросын Холбооны Улстай тусгай зориулалтын гарцтай холбох авто замын зураг төслийн ажилд 5,228.14 сая төгрөг, 4. Барилгын материалын логикийн төв байгуулах 3 га газарт ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажилд 128.0 сая төгрөг, 5. Бүсийн 12 га талбайд мэдээлэл теле хяналтын нэгдсэн системд холбох ажилд 553,90 сая төгрөгийн төсвийн саналыг тус тус боловсруулж, нийт 82,220.49 сая төгрөгийн санхүүжилтийг 2027 оны улсын төсөвт тусгуулахаар төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн рiмiс системд шаардлагад нийцүүлэн мэдээллийг нэгтгэж оруулсан.	100%
4.20	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина	-	Хэрэгжилт, хувь	100% (2025)	100% (2026)	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2026 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Алтанбулаг сумын Цөх 3 дугаар багийн Согоотын амны өндөр хүчдэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын доорх 32 ширхэг нарс модыг сийрэгжүүлэлт хийж, ачиж тээвэрлэн авирч “Хур ирмүүн билэг чөлөөт бүс” ХХК-ний хажуугийн талбайд суулгах ажлыг, ДБХГХХ-ийн инженер, мэргэжилтэн, ААҮАТ-ийн ажилчид хийж	100%

						гүйцэтгэсэн.	
Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт: Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртлыг багасгах, байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай хүргэнэ							
5.1	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын 2025 оны үйл ажиллагааны баримт материалыг архивлан бичиг хэрэг, архив хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө.	-	Гүйцэтгэлийн хувь	100% (2025)	100% (2026)	Архивын Ерөнхий газарт Алтанбулаг чөлөөт бүсийн 2003-2024 оны байнга хадгалах архивын 507 ширхэг боть 51 хайрцаг хөтлөх нэрийн баримтыг 2026 оны 06 сарын 03-ны өдөр хүлээлгэн өгсөн. Тайлант хугацаанд хэлтсийн 2025 оны үйл ажиллагааны архив үйлдэх холбогдох баримт 21 боть материал хүлээн авч ажилласан.	100%
5.2	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангана.	-	Арга хэмжээний тоо	3 (2025)	3 (2026)	Захирагчийн 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/05 дугаартай “Ёс зүйн дэд хорооны гишүүдийг шинэчлэн байгуулах тухай” захирамжаар Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргаар Гэрээ, эрх зүй хариуцсан мэргэжилтэн М.Намуун сонгогдсон. Ёс зүйн дэд хорооны 2026 оны төлөвлөгөө, ирсэн гомдол мэдээллийг цаг тухайд нь бүртгэх, тэдгээрийн шийдвэрлэлт зэргийг тухай бүрт нь цахим системд оруулсан. Хагас жилийн байдлаар: 1 гомдол мэдээллийг хянан шалган, шийдвэрлэж ажилласан.	100%
5.3	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллггааны удирдлагын нэгдсэн систем https://erp.e-mongolia.mn/ -ийг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах, ирсэн болон явсан албан бичгийг хугацаанд	-	Шийдвэрлэлтийн хоногийн тоо	99.3% (2025)	100% (2026)	Албан хэрэг хөтлөлтийн https://erp.e-mongolia.mn/ цахим системийн функцуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглан, 2026 оны эхний хагас жилийн байдлаар албан бичгийг хүлээн авч, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, Тайлант хугацаанд албан бичгийг төлөвлөн холбогдох дээд газар, албан байгууллагад хүргүүлэн ажилласан. Албан хаагч болон аж ахуйн нэгжээс ирсэн 12	100%

	нь бүртгэх, шилжүүлэн, шийдвэрлэнэ.					хүсэлт, гомдолыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж ажилласан.	
5.4.	Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем https://hrm.csc.gov.mn/-д төрийн албан хаагчийн бүртгэл, хөдөлгөөн, холбогдох бичиг баримтын бүрдүүлэлтийг тогтмол оруулна.	-	Хэрэгжилтийн хувь	100% (2025)	100% (2026)	“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем /hrm.csc.gov.mn/-д ажилд томилогдсон болон ажлаас чөлөөлөгдсөн, шилжин ажилласан албан хаагчийн бүртгэл, хөдөлгөөн, холбогдох бичиг баримтын бүрдүүлэлтийг тухай бүрт нь тогтмол оруулан мэдээллийг шинэчлэн ажилласан. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 521 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг шинэчлэн баталсантай холбогдуулан нийт 35 албан хаагчийн хувийн хэргийн хавтас, бүрдүүлэлтийг шинэчилсэн.	100%
5.5	Хуулийн үйлчлэлд хамаарах албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд гаргуулах meduuleg.iaac.mn сайтад оруулах, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулна.	-	Хэрэгжилтийн хувь	100% (2025)	100% (2026)	Хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор мэдүүлсэн-1, албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргасан-8 албан тушаалтны мэдүүлгийг meduuleg.iaac.mn сайтаар хянаж, бүртгэлийг хийж баталгаажуулсан. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 1 этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг meduuleg.iaac.mn хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсан.	100%
Зорилт 1-ийн хэрэгжилт Зорилт 2-ийн хэрэгжилт Зорилт 3-ийн хэрэгжилт Зорилт 4-ийн хэрэгжилт Зорилт 5-ийн хэрэгжилт						2 арга хэмжээ – 90% 2 арга хэмжээ – 50% 8 арга хэмжээ – 93% 20 арга хэмжээ – 92.5% 5 арга хэмжээ – 100%	

НИЙТ ҮНЭЛГЭЭ					Нийт 37 арга хэмжээ төлөвлөж ажилласнаас хэрэгжилт 85.1%-тай байна.	
--------------	--	--	--	--	---	--

---oOo---